



АНС-ИЙН ӨВЛИЙН ЦАГ АГААРЫН ЖУРАМ

Бид Хэрхэн Шийдвэр Гаргадаг Тухай

Бидний анхаардаг асуудлууд:

1. Сурагчид, ажилтнууд болон тэдний гэр бүлийн аюулгүй байдал;
2. Цаг агаарын хэм, хүйтэн салхи, цас/мөс хуримтлагдсан;
3. Автобусны аюулгүй ажиллагаа болон жолоочийн аюулгүй байдал.

1. Урьдчилан Сэргийлэх Мэдээ

Үндэсний Цаг Уурын Албаны цаг агаарын таагүй байдлын урьдчилсан мэдээ.

2. Зохицуулалт

Сургуулиуд болон Дүүргээс хариу арга хэмжээг авч зохицуулна.

3. Үдшийн Шийдвэр

Хэрэв цаг агаарын байдлаас автобусны өглөөний цагийн хуваарьт өөрчлөлт орох бол оройн 18:00 цагаас өмнө мэдээлэх болно.

4. Өглөөний 4:30 Хянан Шалгалт

Үндэсний Цаг Уурын Албаны цаг агаарын урьдчилсан мэдээ, шинэчлэлтийг хянан шалгана.

5. Зохицуулалт

Сургуулиуд болон Дүүргүүд хариу арга хэмжээг авч зохицуулна.

6. Өглөөний Шийдвэр

Шинэчлэгдсэн эсвэл шинээр гаргасан шийдвэрийг өглөөний 5 цаг гэхэд зарлан мэдэгдэнэ.

Хичээлийн үеэр цас/мөс орж эхэлбэл

1. Цас эсвэл мөс орж эхлэх эсвэл хуримтлах талаар урьдчилан мэдээлсэн үед:

1. **ХЭРЭВ** хуримтлал нь автобусны үдээс хойшхи цагийн хуваарьт нөлөөлөх бол **ТЭГВЭЛ** өглөөний 11:30 цаг гэхэд хичээл хэдэн цагт тарах эцсийн шийдвэрийг гарган мэдэгдлийг АНС-ийн Talk сувгаар дамжуулан мэдээлэх болно.

2. **ХЭРЭВ** хуримтлал нь автобусны үдээс хойшхи цагийн хуваарьт нөлөөлөхгүй бол **ТЭГВЭЛ** хичээл цагтаа тарах болно. Хэрэв урьдчилан сэргийлэх үүднээс оройн арга хэмжээ, хичээл цуцлагдах бол оройн 18:00 цагаас өмнө АНС-ийн Talk сувгаар дамжуулан мэдээлэх болно.



Arlington
Public
Schools